

*Дундговь аймгийн Хулд сумын  
иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
2021 оны 01 дүгээр сарын 13 – ны  
өдрийн...дугаар тогтоолын ... дүгээр  
хавсралт*

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨР**

**УЛААНЖИРЭМ**

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна гэсэн заалтыг үндэслэж, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.

Хулд сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Дундговь аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан боловсруулахаас гадна Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэн боловсруулсан. Уг бодлогын баримт бичигт иргэд, олон нийтийн саналыг тусгахдаа сумын Засаг даргын Тамгын газрын цахим хаяг, цахим хуудсаар дамжуулан саналыг авсан. Тус хөтөлбөрт тусгуулахаар нийт 250 иргэн иргэний нийгмийн болон төрийн байгууллага, албан хаагчдаас 30 санал ирүүлснийг холбогдох байгууллагуудад хуваарилан өгч саналыг эрэмбэлэх, бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилттой уялдах байдал, хөтөлбөрт тусгахад хэрэгжих боломжийг судлуулан тооцуулж, тусган ажилласан.

Ирүүлсэн нийт саналын 80 орчим хувь нь гол утга санаа, агуулгын хувьд Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дундговь аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцэж сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаад байна.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бүлэг 18 чиглэл 16 зорилго 39 зорилт 159 арга хэмжээг төлөвлөн гаргалаа.

(Бүлэгт хамаарах зорилт, арга хэмжээний тоог графикаар харуулбал)

Бүлэг	Салбарын тоо/ зорилгын тоо	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1. Ковид 19 халдварт цартахлын хүндрэлийг даван туулах	1	1	7
2. Хүний хөгжлийн бодлого	5	16	58
3. Эдийн засгийн бодлого	5	9	30
4. Засаглалын бодлого	3	7	41
5. Ногоон хөгжлийн бодлого	1	4	14
6. Орон нутгийн хөгжлийн бодлого	1	2	9
<b>Нийт</b>	<b>16</b>	<b>39</b>	<b>159</b>

Хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн зарим суурь төвшин зорилтот төвшинг тодорхойлохдоо 2014 -2020 оны суурь судалгаанд үндэслэсэн бөгөөд Аймгийн статистикийн хэлтэс, төрийн байгууллага, албан хаагчдын мэдээллийн санд тулгуурлан тооцож төлөвлөсөн болно.

АЖЛЫН ХЭСЭГ

## **АГУУЛГА**

### **НЭГ.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО**

1.1 Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх

#### **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 2.1 Эрүүл мэнд
- 2.2 Биеийн тамир, спорт
- 2.3 Боловсрол
- 2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- 2.5 Үндэсний бахархал, өв соёл

#### **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 3.1 Санхүү, төсвийн зохицуулалт
- 3.2 Уул уурхай,
- 3.3 Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр
- 3.4 Аялал жуулчлал
- 3.5 Эрчим хүч

#### **ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

- 4.1 “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ
- 4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба
- 4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм
- 4.4 Гадаад харилцаа
- 4.5 Батлан хамгаалах

#### **ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 5.1 Ногоон хөгжил

#### **ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

### НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

**Зорилго:** Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2020 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.

**Зорилт: 1.1.** Коронавирусын халдвар /ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлнэ.

**Арга хэмжээ:**

1.1.1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.

1.1.3. Коронавируст халдвар /covid-19/-ын түргэвчилсэн оношлуур, хамгаалах хувцасны нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, тусгаарлах байрны бэлэн байдлыг хангана.

1.1.4. Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулна.

1.1.5. Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын сургуульд нэвтрүүлэх

1.1.6. Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангана.

1.1.7. Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт, арга хэмжээнд хамруулна.

### ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Зорилго:** Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн, хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 0.689 байсныг 2024 онд 0.719 хувиар нэмэгдүүлнэ.

#### 2.1 Эрүүл мэнд

**Зорилго:** Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дунд халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

**Зорилт: 2.1.1.** Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийн төвшинг нэмэгдүүлнэ.

**Арга хэмжээ:**

2.1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр “Эрүүл мэндийг дэмжих танхим” байгуулна.

2.1.1.2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлэх.

2.1.1.3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулна.

**Зорилт: 2.1.2.** Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан 0-5 насны хүүхэд болон эхийн эндэгдэлгүй ажиллана.

**Арга хэмжээ:**

2.1.2.1. Сумын эмнэлгийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулна.

2.1.2.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**Зорилт: 2.1.3.** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.

**Арга хэмжээ:**

2.1.3.1. Эхо аппарат, зөөврийн тоног төхөөрөмж, сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангана.

2.1.3.2. Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлнэ.

2.1.3.3. Сумын эмнэлэгтээ хүлээн авах яаралтай тусламжийн иж бүрдэлтэй болгох, өрх бүрийг анхан шатны тусламжийн эмийн сантай болгох ажлыг зохион байгуулна.

2.1.3.4. Эм, эргэлтийн сангийн менежментийг сайжруулж, өргүй болгож, ашигтай ажиллуулах ажлыг зохион байгуулна.

2.1.3.5. Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн тоног төхөөрөмжөөр хангах.

2.1.3.6. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний унааны асуудлыг шийдвэрлэнэ.

## 2.2 Биеийн тамир, спорт

**Зорилго:** Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн төвшин тогтоох сорилд хамрагдагчдын тоог нэмэгдүүлж, эрүүл аж төрөх арга барил, зан үйлийг нэмэгдүүлнэ

**Зорилт:** 2.2.1. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгсдийн тоог жил бүр нэмэгдүүлэх.

**Арга хэмжээ:**

2.2.1.1. Төрийн болон ТББ-ын спорт хамтлагуудын үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжих

2.2.1.2. Гэр бүл, хамт олонд эрүүл аж төрөх арга барил зан үйлийг төлөвшүүлэх, хөтөлбөр боловсруулах

2.2.1.3. Үндэсний болон спортын холбоодын үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжиж ажиллана.

2.2.1.4 "Бага олимп" наадмын бүх төрөлд тамирчдыг бэлтгэн оролцуулах

2.2.1.5 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд сумын 3-64 насны нийт хүн амын 20-оос дээш хувийг хамруулах

## 2.3 Боловсрол

**Зорилго:** Сургууль, цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулах, багш, хүүхдийн хөгжлийг дэмжиж, ЕБС-ын чанарын үнэлгээний дундаж 73,8 хувь байсныг 75 хувьд хүргэж өсгөнө.

**Зорилт: 2.3.1.** Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 77,4 хувь байсныг 2024 онд 80 хувьд хүргэнэ.

**Арга хэмжээ:**

2.3.1.1. Хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барих;

2.3.1.2. Сум тойргийн хоёроос дээш насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд ердийн бүлгээр хамруулж, баг бүрд хувилбарт сургалтыг зохион байгуулж гэр цэцэрлэг ажиллуулна.

2.3.1.3. СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмж, байгаль нийгэмшихүйн хөгжлийг хангах туршилтын талбай байгуулах, гадаад талбайн тоглоом наадгайгаар хангана.

**Зорилт:** 2.3.2. ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 59,3 хувь байсныг 2024 онд 65 хувьд хүргэж, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулна.

**Арга хэмжээ:**

2.3.2.1. Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалтууд зохион байгуулж багш нарын мэргэжил ур чадварыг сайжруулна.

2.3.2.2. Хэлний бодлогын зөвлөл, боловсролын байгууллагуудыг түшиглэн үндэсний бичиг олон талт арга хэмжээг зохион байгуулах ажлыг дэмжих

2.3.2.3 Сумын насан туршийн боловсролын нэгжээр дамжуулан иргэдэд амьдрах ухаан, 8-9 –р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулна.

**Зорилт:** 2.3.3. Багш ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжих ажлыг зохион байгуулах;

**Арга хэмжээ:**

2.3.3.1. Багш нарыг гадаад, дотоодод туршлага судлуулах, сумын шилдэг багш, хүүхдийг шалгаруулж урамшуулна.

2.3.3.2. Бага, суурь боловсролын багш нарыг 100 хувь зөвлөх багийн үйлчилгээнд хамруулна.

2.3.3.3. “Чадварлаг багш –Чанартай боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэх

2.3.3.4. “Хүмүүжил төлөвшилтэй хүүхэд – “Хулдын ирээдүй” өдөрлөг, удирдамж, аян зохион байгуулж шалгаруулна.

**Зорилт:** 2.3.4. ЕБС-ийн биеийн тамирын хичээл, урлаг заалыг шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангана.

**Арга хэмжээ:**

2.3.4.1. Сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулна.

2.3.4.2. Байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулна.

2.3.4.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулна.

2.3.4.4. Багш хөгжлийн өрөөг өргөжүүлэх, техник хэрэгслээр хангах, багшаа чадваржуулна.

2.3.4.5. ЕБС-ийн барилгыг их засварт оруулах ажлыг эхлүүлнэ.

## 2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

**Зорилго:** Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, ажиллах хүчний оролцооны төвшинг нэмэгдүүлнэ.

**Зорилт:** 2.4.1. Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг жил бүр өсгөн нэмэгдүүлнэ.

**Арга хэмжээ:**

2.4.1.1. Иргэдэд үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.4.1.2. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээгээр үйлчлүүлэх иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.

**Зорилт:** 2.4.2. Ажлын байрыг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

2.4.2.1. Сумын ажил эрхэлдэггүй иргэдийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, иргэдийн санаа бодлыг сонсон, шинэ ажлын байр бий болгох, бодлого чиглэлээ тодорхойлно.

2.4.2.2. Иргэдийн хүсэл сонирхол, чадвар, чадамжид тулгуурлан нөхөрлөл байгуулах, хөтөлбөр бусад арга хэмжээнд хамруулах замаар ажлын шинэ байр бий болгоно.

2.4.2.3. Хөдөлмөр эрхлэлтийн албаны талаарх ойлголтыг илүү өргөн хүрээнд мэдээлж, бүртгэлтэй ажил хайж байгаа иргэдээс сул чөлөөтэй байнгын ажлын байранд зуучлана.

2.4.2.4. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн /310 ба түүнээс доош оноотой\ ажил эрхлэхгүй байгаа иргэдийн ажил эрхлэх санаачилгыг дэмжинэ.

**Зорилт: 2.4.3.** Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага шалгаруулах аймгийн болзлыг ханган ажиллана.

**Арга хэмжээ:**

2.4.3.1. Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд жилд хоёроос доошгүй удаа хамруулах

2.4.3.2. Ахмад настнуудыг нас, бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах ажлыг дэмжинэ.

2.4.3.3. Сумын ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулна.

2.4.3.4. Ахмадын байрны орчин нөхцөлийг сайжруулна.

**Зорилт: 2.4.4** Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт 2020 онд 85 хувь байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ.

**Арга хэмжээ:**

2.4.4.1. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 65-аас доошгүй хувийг чадваржуулах сургалтад хамруулна.

2.4.4.2. Хүүхэд, залуусыг улс, бүс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх, амжилттай оролцсон тохиолдолд шагнаж урамшуулан алдаршуулна.

2.4.4.3. Хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулан, орчин үеийн стандартад нийцсэн тоглоом, хэрэглэгдэхүүнтэй болгоно.

**Зорилт: 2.4.5.** Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

**Арга хэмжээ:**

2.4.5.1. Залуучуудын салбар зөвлөлийн ажлыг тогтмолжуулах;

2.4.5.2. Залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих

2.4.5.3. Олон улсын гэр бүлийн өдрийг жил бүр зохион байгуулах

## 2.5 Үндэсний бахархал, өв соёл

**Зорилго:** Соёлын ажлын агуулга хэлбэр, төрөл зүйл, чанар хүртээмж, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, материаллаг баазыг бэхжүүлэх.

**Зорилт: 2.5.1.** Үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, материаллаг баазыг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

2.5.1.1. Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанарыг сайжруулж, нэмэгдүүлнэ

2.5.1.2. Урлагийн иж бүрэн хувцастай болгоно.

2.5.1.3. Соёл урлагийн задгай талбай байгуулж хашаажуулна

2.5.1.4. Орон нутаг судлах танхим байгуулна

**Зорилт 2.5.2.** Соёлын төвийг мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

**Арга хэмжээ:**

2.5.2.1. Соёлын төвийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэн, шаардлагатай боловсон хүчнийг үе шаттай сургах төлөвлөлт хийж мэргэжил мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

2.5.2.2. Орон нутагт дутагдалтай байгаа боловсон хүчнийг мэргэжлийн их, дээд сургуулиудад сум, байгууллагын гэрээгээр суралцуулан бэлтгэж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлнэ

**Зорилт: 2.5.3.** Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх

**Арга хэмжээ:**

3.5.3.1. Морин хуур, уртын дууны сургагч багш нарыг бэлтгэн, сургалт явуулж, морин хуурын хамтлаг, уртын дууны чуулга байгуулан, дуу хуураа өвлүүлэн хөгжүүлнэ

2.5.3.2. Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээт хамгаалагчтай болгоно

2.5.3.3. Орон нутаг судлах танхимыг түшиглэн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлнэ

2.5.4.4. Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлж урьд оноос нэмэгдүүлнэ.

2.5.4.5. Угийн бичгийн сургалтыг явуулж, үр дүнг тусгай болзол журмын дагуу дүгнэнэ

## ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 3.1 Санхүү, төсвийн зохицуулалт

**Зорилго:** Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын баазыг нэмэгдүүлэх.

**Зорилт:** 3.1.1.Татварын тухай хууль болон цахим татварын бүх төрлийн үйлчилгээг иргэдэд сурталчлах

**Арга хэмжээ:**

3.1.1.1. Татвар төлөгчдийн нэгдсэн арга хэмжээний өдөрлөгийг зохион байгуулж, иргэд, ААН, татвар төлөгчдийг хамруулж төрийн үйлчилгээг үзүүлнэ

3.1.1.2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 90 дээш хувь биелүүлнэ

**Зорилт:** 3.1.2. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтад орон нутгийн аж ахуйн нэгжийн оролцоо, эзлэх хувийг нэмэгдүүлнэ

**Арга хэмжээ:**

3.1.2.1. Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймаг сумын вебсайт болон цахим хуудсаар тухай бүр мэдээлнэ

3.1.2.2. Орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, үнэлгээний хорооны гишүүдийг сургаж чадавхиулна

3.1.2.3. Хадгаламж зээлийн хоршоог шинээр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

### 3.2 Уул уурхай

**Зорилго:** Уул уурхайн салбарын сумын эдийн засаг нийгэмд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж, хариуцлагатай уул уурхайг дэмжих

**Зорилт:** 32.2 Суманд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн тусгай,зөвшөөрөл, дүгнэлттэй газруудтай хамтран ажиллах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**



3.2.1.1. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн хөгжлийг бодитой дэмжих талаар хамтран ажиллана.

3.2.1.2. Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль, хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулна

### **3.3. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр**

**Зорилго:** Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний төрлөөр орон нутгийн иргэдийн хэрэгцээний зохих хувийг хангаж, иргэдийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.

**Зорилт:** 3.3.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг жил бүр өсгөн нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

3.3.1.1. Мал төхөөрөх, нядалгааны цэг байгуулна.

3.3.1.2. Орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоодын зах зээлд нийлүүлэх малчид, хоршоод, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж, ХАА-н бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.

3.3.1.3. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх малчин өрхийн тоог нэмэгдүүлнэ

3.3.1.4. Ноос, арьс ширний анхан шатны боловсруулалт хийх, иргэдийн санал санаачилгыг дэмжинэ

3.3.1.5. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжинэ

3.3.1.6. Хүнсний бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөлд хяналт тавьж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

**Зорилт:** 3.3.2. Малын тоог чанарт шилжүүлж, орчин үеийн шинэлэг ололтыг нэвтрүүлэн малын генетик нөөцийн чанарыг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

3.3.2.1. Олдохын хүрэн бор омгийн тэмээний тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлж бусад аймаг, сумдад сайжруулагчаар ашиглуулна

3.3.2.2. Сумын хэмжээнд бог малын сайжруулагч хээлтүүлэгчийг ашиглаж, малын тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлнэ.

3.3.2.3. Жилд 5-аас доошгүй стандартын шаардлага хангасан бух бойжуулж, үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулна

3.3.2.4. Стандартын шаардлага хангасан цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулна

**Зорилт:** 3.3.3. Бэлчээр ашиглагчдын хэсгийг чадавхжуулан дэмжих замаар бэлчээрийг зохистой ашиглаж нөхөн сэргээх

**Арга хэмжээ:**

3.3.3.1. Малчин өрхийн өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй бий болгох зорилгоор хашиж хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлнэ

3.3.3.2. Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана

3.3.3.3. Малын бэлчээрийн талбайд гүн өрмийн худаг гаргах, энгийн уурхайн худгуудыг засварлана

**Зорилт:** 3.3.4. Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлж вакцингүй эрүүл малын эзлэх хувийг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

3.3.4.1. Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ олгоно

3.3.4.2. Мал угаалгын суурин ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх хашаа барина.

3.3.4.3. Сумын хэмжээнд тарилгын вакцин хадгалах хөргүүр, малчин өрх бүрийг мал эмнэлгийн аптектай болгох, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг ажил үйлчилгээ явуулахад шаардагдах нөхцөл бололцоогоор хангана.

3.3.4.4. Мал эмнэлэг, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн тоог нэмэгдүүлж, малчин өрхийн мал сүрэгт үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### **3.4 Аялал жуулчлал**

**Зорилго:** Орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх

**Зорилт:** 3.4.1. Аялал жуулчлалын маршрутад сумыг хамруулах ажлыг зохион байгуулж аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн бизнесийг дэмжин хөгжүүлэх

**Арга хэмжээ:**

3.4.1.1. Төв зам дагуу үйлчилгээний газруудад эко ариун цэврийн байгууламж байгуулах, сумын аялал жуулчлалын самбар байгуулна

3.4.1.2. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал хөгжүүлнэ

3.4.1.3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох "Говийн зэрэглээ" төслийг дэмжин хамтарч ажиллана

3.4.1.4. Цагаан суваргын аялал жуулчлалын маршрут төв зам, эрчим хүчний давуу тал, Тугалын бүлээний рашааныг түшиглэн үйлчилгээний газар байгуулах төсөл, санал санаачилгыг дэмжинэ.

### **3.5 Эрчим хүч**

**Зорилго:** Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг хангах

**Зорилт:** 3.5.1. Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг засварлан шинэчлэх

**Арга хэмжээ:**

3.5.1.1. Сумын төвийн 0,4кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг иж бүрэн сольж төмөр бетон тулгууртай СИП кабель шугамтай болгоно.

3.5.1.2. Төрийн байгууллагуудыг болзошгүй үед хэрэглэх тохирсон хүчин чадал бүхий цахилгааны нөөц эх үүсвэртэй болгоно.

### **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**Зорилго:** Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

**Зорилт:** 4.1.1. "Цахим Монгол"-төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулах.

**Арга хэмжээ:**

4.1.1.1. "Цахим Хулд " хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ

4.1.1.2. Сумын үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийх, үйлчилгээний хурд чанарыг сайжруулна

4.1.1.3. Сумын удирдлагуудын иргэдтэй хийх цахим уулзалт, цахимаар мэдээлэл хүргэх, мэдээлэл солилцох эргэх холбоо бүхий арга хэрэгслийг боловсронгуй болгон үр дүнд хүргэнэ

4.1.1.4. Архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар, хүндрэлгүй чирэгдэлгүй, үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ

4.1.1.5. Архивыг нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

4.1.1.6. Баг байгууллагад багц мессеж үйлчилгээг ашиглан сумын бүх өрхөд шаардлагатай мэдээллийг мессежээр хүргэх эргэх холбоо үүсгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.1.1.7. Төрийн үйлчилгээний “Хур” системийн мэдээллийг ашиглан 53 нэр төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, үйл ажиллагааг сайжруулан үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамжийг хувийг жил бүр нэмэгдүүлнэ

4.1.1.8. Иргэний бүртгэлийн үйлчилгээний “Гэрэгэ” систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн иргэний зөрчлийг бүрэн арилгана

4.1.1.9. Иргэний улсын бүртгэлийг онлайнд холбож, улсын бүртгэлийн үйлчилгээний сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ

4.1.1.10. Ухаалаг дэлгэц ашиглан төрийн үйлчилгээнд шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх материалтай танилцаж, хүсэлт илгээдэг болох асуудлыг судлан шийдвэрлэнэ

4.1.1.11. Эхний ээлжинд ИТХурал, ЗДТГ-ын ажилтнууд, цаашид үе шаттайгаар бүх төрийн албан хаагчдыг зөөврийн компьютер, улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн шугамаар бүрэн хангаж, орон зай, цаг хугацаа, гамшгийн хүчин зүйлээс үл хамааран төрийн ажил, үйлчилгээг үр дүнтэй цахимаар явуулах боломж бүрдүүлнэ.

4.1.1.12. Сумын төвд нийтэд зар мэдээ хүргэдэг арга хэрэгслийг боловсронгуй болгон гудамж хорооллыг аравтын системд хамруулах, иргэдийг идэвхжүүлэх арга хэмжээ зохион байгуулах, 4-5 цэгт мэдээлэл хийдэг хэрэгсэлтэй болгоно.

## **4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба**

**Зорилго:** Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил бууруулна.

**Зорилт:** 4.2.1. Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэх, томилгооны зөрчлийг бууруулах

### **Арга хэмжээ:**

4.2.1.1. Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх

4.2.1.2. Ажилтнуудыг болон шинээр албанд томилогдсон иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулан чадавхжуулна

4.2.1.3. Сумын дотоод, гадаадад амжилттай суралцагч, сум орон нутагтаа ажиллаж амьдрах хүсэлт гаргасан оюутан залуучуудтай гэрээ хийж, орон нутагт тогтвор суурьшилтай үр дүнтэй ажиллах сонирхол төрүүлэхүйц нийгмийн болон эдийн засгийн боломж бүрдүүлнэ.

4.2.1.4. Төрийн албан хаагчдын оффисын техник хэрэгсэл ашиглах чадварыг сайжруулах, албан бичиг хэрэг боловсруулах сургалтуудыг зохион байгуулж чадвар бүтээмжийг нэмэгдүүлнэ

4.2.1.5. Иргэд төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна

4.2.1.6 Шилжиж ирж байгаа боловсон хүчнийг орон байраар хангаж, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ

4.2.1.7 Орон нутгийн боловсон хүчний бодлогыг тодорхойлно.

4.2.1.8 Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулан удирдах албан хаагчийн манлайллыг үзүүлж албан хаагчдын сургалтын хэрэгцээг хангаж мэргэшүүлэх

**Зорилт: 4.2.2.** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог сайжруулж, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

4.2.2.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлэх ажил зохион байгуулж, санаачлагыг дэмжин ажиллана.

4.2.2.2. Сумын эрх бүхий албан тушаалтныг чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулна

**Зорилт: 4.2.3.** Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд зохион байгуулах;

**Арга хэмжээ:**

4.2.3.1. Хөдөөгийн малчид, иргэдэд чиглэсэн олон нийтийн, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн, урлаг соёлын арга хэмжээ, нэгдсэн төрийн үйлчилгээг явуулаар үзүүлэх, байр, техникийн шийдэл олж, хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр багуудад 1-2 удаа зохион байгуулна

4.2.3.2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулна

4.2.3.3. Орон нутгийн ИНБ-уудын оролцоо хамтын ажиллагаанд тулгуурлан жендэрийн боловсрол олгох, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх сургалт, аяныг гэрээлэн гүйцэтгүүлнэ

### **4.3 Амар тайван, аюулгүй нийгэм**

**Зорилго:** Цагдаагийн хэсгийн материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг нэмэгдүүлэх;

**Зорилт: 4.3.1.** Гэмт хэрэг болон зам тээврийн ослын хэмжээг бууруулах

**Арга хэмжээ:**

4.3.1.1. Архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн хөтөлбөр боловсруулан, цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ

4.3.1.2. Сумын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”, “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжин ажиллана

4.3.1.3. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулна

4.3.1.4. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачилга, оролцоотой гэр хорооллын гудамж, сумын төв талбай, төрийн байгууллага, худалдаа үйлчилгээний газруудыг дэвшилтэт технологи бүхий камержуулалт, гэрэлтүүлгийн системтэй хослуулан үр дүнтэй хяналтын системийг нэвтрүүлнэ

4.3.1.5. Мал хулгайлах, эд зүйлийн хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэд, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна

4.3.1.6. Хэсгийн мөрдөгч, цагдаа нарын албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, цагдаагийн хэсгийн байрны тохижилт, замын постын үйл ажиллагааг тогтмолжуулж сайжруулах талаар анхаарч иргэд, олон нийтийн болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ

**Зорилт:** 4.3.3.

Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ.

**Арга хэмжээ:**

4.3.3.1. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах сэрэмжлүүлэх, асуудлыг багц мессеж үйлчилгээг ашиглан 100 хувь шийдвэрлэнэ.

4.3.3.2. Гамшгаас хамгаалах мэргэжил ангийн 66 хүний нөөцийг жил бүр тодотгон шинэчилж, зориулалтын хувцас, тоног хэрэгслээр бүрэн хангаж гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулна. Сургалтанд мэргэжил ангийн бүрэлдэхүүнийг 100 хувьд хамруулна.

4.3.3.3. Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, 2 жилд 1 удаа дадлага сургууль, үзлэг зохион байгуулах;

4.3.3.4. Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион, байгуулах, ажиллах хүн, хүч байрны асуудлыг шийдвэрлэнэ

4.3.3.5. Хүн, малын халдварт өвчин, цар тахлын үеийн болзошгүй бэлэн байдлын хангалтыг зохих төвшинд бүрдүүлэх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдүүлнэ.

**4.4 Гадаад харилцаа**

**Зорилт:** 4.4.1. Гадаадын хамтын ажиллагаатай болох, гадаадын хөрөнгө оруулалттай болох ажлыг эхлүүлэх

**Арга хэмжээ:**

4.4.1.1. Гадаадын хамтын ажиллагаатай, олон улсын төслийн байгууллагатай түншлэх асуудлыг судлана

4.4.1.2. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт арга хэмжээнд хамруулна

**4.5 Батлан хамгаалах**

**Зорилт:** 4.5.1. Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамжийг сайжруулах

**Арга хэмжээ:**

4.5.1.1. Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний үйл ажиллагааг сурталчилан таниулах;

4.5.1.2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүнийг сургах дадлагажуулах, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэн нөөцийг бүрдүүлнэ

4.5.1.3. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулна

**ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**5.1 Ногоон хөгжил**

**Зорилго:** Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Зорилт:** 5.1.1. Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 4 хувиар бууруулна.

**Арга хэмжээ:**

5.1.1.1. Утааг багасгах чиглэлээр утаа бага ялгаруулдаг зуух хэрэглэгч, төвлөрсөн дулаанд холбогдсон айл өрх байгууллагын тоог нэмэгдүүлнэ.

5.1.1.2. Айл өрхийн сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох иргэд, өрхийн санал санаачлагыг дэмжин ажиллана

5.1.1.3. Төв зам дагуу үйлчилгээний газар, байгууллага аж ахуйн нэгж, аялал жуулчлал, уул уурхайн бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлнэ

5.1.1.4. Хог хаягдлын менежментийг сайжруулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.

5.1.1.5. Сумын хогийн савны тоог нэмэгдүүлнэ

5.1.1.6. Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 2 эх үүсвэрт суурилуулна

5.1.1.7. Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулна

5.1.1.8. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг 100 хувь зохион байгуулна

**Зорилт:** 5.1.2.

Ногоон байгууламжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэх;

**Арга хэмжээ:**

5.1.2.1. Нийтийн эзэмшлийн газруудад ногоон байгууламжийг бий болгох ажлыг эхлүүлнэ.

**Зорилт:** 5.1.3.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 20 га газрын нөхөн сэргээлтийн ажлыг 30 хувьд хүргэнэ.

**Арга хэмжээ:**

5.1.3.1. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 6 га-д хийлгэнэ

5.1.3.2. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх ажлыг хийлгэнэ

5.1.3.3. Мод үржүүлгийн туршилтын талбай байгуулна.

5.1.3.4. Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулна

**Зорилт:** 5.1.4.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх

**Арга хэмжээ:**

5.1.4.1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулна.

## **ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Зорилго:** Сумын ерөнхий төлөвлөгөөг иргэдийн оролцоотой боловсруулан бүх төлөвлөлттэй уялдуулах.

**Зорилт:** 6.1.1 Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар зохион байгуулалт, дэд бүтцийн ажлуудыг эхлүүлэх

**Арга хэмжээ:**

6.1.1.1. Төвлөрсөн цэвэр бохирын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж байгуулах ажлыг судлан хэрэгжүүлнэ

6.1.1.2. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан баталж мөрдөж ажиллана

6.1.1.3. Иргэдийн газар өмчлөлийг хувийг нэмэгдүүлж, жишиг гудамж төсөл, сумын тохижилт, соёлжилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, эхлүүлнэ

6.1.1.4. Суманд орон сууцны барилга барих хөрөнгө оруулах, төсөл санаачилгыг дэмжин ажиллана

6.1.1.5. Сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барих зураг төсвийг боловсруулан хөрөнгийн асуудлыг аймгийн удирдлага, Улсын Их Хурлын гишүүдтэй хамтран шийдвэрлэж шинэ байртай болгоно

6.1.1.6. Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөнө

6.1.1.7. Малчдын өвөлжөө, хаваржааны газрын маргаантай асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ

**Зорилт:** 6.1.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ

**Арга хэмжээ:**

6.1.2.1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээ, хэрэгжилтийг иргэд олон нийтэд мэдээлэх, tusuv-oron nutag.mn сайтад тухай бүр оруулна

6.1.2.2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний иргэдийн саналыг цахимаар авч оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

БОЛОВСРУУЛСАН: ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГА  
ПЭРЭНЛЭЙ ОВОГТОЙ БЯМБАЛХАГВА

2021 оны 01 сарын 01 ны өдөр